

Дуут сумын байгальд ээлтэй сургууль



Уриа: “ Байгальд – хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлье”

Логооны тайлбар “Байгаль эх дэлхийгээ өөрийн амь шигээ хайрлацгаая гэсэн утга санааг илэрхийлсэн хөрс шороон дээр 2 гар дээрээ байгаль орчноо өргөн дээдэлэе” гэсэн утга санааг илэрхийлсэн болно.

- 1. Түүхэн замнал:** Ховд аймгийн Дуут сумын сургууль 12 жилийн дунд сургууль нь 2010-2011 оны хичээлийн жилд 280 суралцагч, 11 анги бүлэг, 20 багш сурган хүмүүжүүлэгч, 15 үйлчилгээний ажилтантайгаар сургалт хүмүүжлийн ажлаа явуулж байна.
- 2. Байгальд ээлтэй сургууль:** Тус сургууль нь 2008 оноос эхлэн төсөл хэрэгжиж байгаа бөгөөд өнөө хүртлэх хугацаанд байгаль орчинд ээлтэй хамт олон болох зорилтыг сургуулийн стратеги төлөвлөгөөнд тусган, “Байгалд ээлтэй сургууль”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсний үр дүнд 2010 онд “Байгалд ээлтэй сургууль” хамт олон болсон. Тус сургууль нь сүүлийн 2-3 жилд сургалтын орчин нөхцөл сайжирч, сургалт хүмүүжлийн ажлын чанар дээшилснээр 2010 онд мэргэжлийн хичээлийн олимпиадад аймагт 2-р байр, төгсөлтийн ерөнхий шалгалтын дүнгээр аймагт 2-р байруудыг тус тус эзэлсний дээр урлаг, спортын уралдаан тэмцээнүүдээс 30 гаруй медаль хүртсэн нь “ Байгалд ээлтэй сургууль” болох зорилтын хүрээнд хийгдсэн сургалтын ая тухтай орчин , нөхцөл бүрдүүлэх чиглэлээр хийгдсэн ажлуудын үр дүн гэж үзэж байна.

Нэгдүгээр алхам: Эко зөвлөл байгуулах.

Тус сургуулийн “Эко зөвлөл ” нь 11 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд сурагчдын “Эко зөвлөл” нь 21 сурагчтай, анги бүхэн эко клубын зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа явуулж байна. Эко зөвлөлөөс нийт ангиудын дунд сургалт сурталчилгааны ажлыг энэ хичээлийн жилд 3 удаа явуулж анги бүхэн цэцэгжүүлэх хөдөлгөөн өрнүүлснээр бүх ангиуд цэцэгтэй боллоо. 2011 оноос “Байгальд ээлтэй сургууль” төслийн үзэл санааг хөдөөгийн малчдад түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах, сум орноороо ногоон байгууламж байгуулах хөдөлгөөн өрнүүлж ажиллахаар төлөвлөж байна. Байгальд ээлтэй сургуулийн үзэл санааг сургуулийн мастер төлөвлөгөөнд тусгуулан, түүнийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг сургуулийн үйл ажиллагаатай нягт уялдуулан явуулж байна.

Хоёрдугаар алхам: Сургуулийн дотоод , гадаад орчны үнэлгээ хийх.

Эко зөвлөлийн сурагчид ажиглалт хийж дүгнэлт гаргах замаар үнэлгээ хийв. Ажиглалт судалгааны явцад сургуулийн гаднах байгаль орчны байдалд үнэлэлт өгч хог хаягдлын цэг, бие засах газар, ногоон байгууламжийн арчлалт хамгаалалтанд үнэлгээ өглөө. 2010 онд сургуулийн урд хэсэгт 100ш бургас суулгасан нь амжилттай ургасан. Цаашид талбайг өргөжүүлэх боломжтой. Шинээр сурагчдын бие засах газрыг хийсэн нь стандарт шаардлагад дөхөж очсон. Сургуулийн орчимд хогийн нэгдсэн цэгтэй болсноор замбараагүй хог хаягдал хаях явдал үгүй болсон.

Төсөл хэрэгжсэнээр манай сургуулийн дотоод, гадаад орчин тодохой хэмжээгээр сайжирч багш, сурагчдын сурч ажиллах таатай орчин нөхцлийг төлөвлөгөөний дагуу бүрдүүлж байна. Мөн сургуулийн ногоон байгууламж жил тутамд нэмэгдэж байгаа, багш сурагчид болоод ард иргэдийн экологийн мэдлэг тодорхой хувиар өөрчлөгдсөн. Тэдний байгальд хандах хандлага өөрчлөгдсөн.

Сургуулийн дотоод орчны хувьд багш сурагч, ажилчид төлөвлөгөө гаргаж ажилласаны үр дүнд тодорхой үр дүнд хүрч байна.

- Коридорт 2 өвөрмөц өвөрмөц нэмж тавьснаар халаалт хэвийн болсон
- 6 анги танхимын цонхыг вакуум цонх болгосноор ангиудын халаалт хэвийн 18⁰-20⁰С болсон.
- Ангиудын агааржуулалт хэвийн болсон.
- Коридорын цэвэрлэгээнд сургуулийн эмч байнгын хяналт тавьж, тоосжилт багассан.
- Бүх анги, кабинетийн гэрэлтүүлэг хэвийн болсон.

Гуравдугаар алхам: Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

1. Хичээлийн байрны дээврийн хучилтыг солих ажлыг шийдэх.
2. Сургуулийн нүүрэн талын ногоон байгууламжийг өргөжүүлэн хайсыг солих
3. Сургуулийн урд хэсэгт сурагчдын чөлөөт цагийг өнгөрүүлэх ногоон бүс байгуулах.
4. Сургуулийн арын хэсэгт ногоон байгууламж бий болгох.
5. Байгальд ээлтэй сургуулийн үзэл баримтлалыг Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан сургалтын хөтөлбөрийг шинэчлэх.

Байгальд ээлтэй сургуулийн мэдээллийн танхимын үйл ажиллагааг өргөжүүлж, сумын иргэдийн сургалт- сурталчилгааны төв болгох.

Дөрөвдүгээр алхам: Хяналт үнэлгээ.

Хяналт үнэлгээг сургуулийн удирдлагууд болон аймгийн БСГ, МБОК-аас хийдэг бөгөөд бидний үйл ажиллагаанд санал, зөвлөгөө өгч ажилладаг. Тухайлбал Иргэний боловсрол хичээлээр олгож буй байгаль орчны боловсрол олгох хичээлд сургалтын менежер байнга хяналт тавин ажилладаг. Мөн эко зөвлөл явуулж байгаа үйл ажиллагаагаа захирал дэргэдэх зөвлөлөөр батлуулж, үр дүнг хянуулдаг.

Тавдугаар алхам : Шинэ техник технологи ашиглан сургалт зохион байгуулах

Иргэний боловсрол хичээлээр байгаль орчны боловсрол эзэмшүүлэх, байгальд ээлтэй сургуулийн онцлогт тохирсон сургалтын хөтөлбөрийг бага, дунд, ахлах ангийн түвшинд болон анги тус бүрээр хийж батлуулан сургалтыг хичээлийн цагийн хуваарьт тусган тогтмол явуулдаг. Багш нарын дунд “Байгаль орчин хичээл”-ийн сэдвийн иж бүрэн боловсруулалт хийх уралдаан зарлаж бүх сэдвээр сургалтын материал бэлтгүүлэн сургалтанд ашиглаж байна. Мөн байгаль орчны мэдээллийн сан ашиглаж хичээл орж байгаа. Мэдээллийн төвийг түшиглэж бүх багш, сурагчдын дунд сургалт явуулахыг зэрэгцээ, хөдөөгийн 3 багийн бэлчээр ашиглалтын хэсгийн малчдад сургалт сурталчилгаа явууллаа.

Зургаадугаар алхам : Орон нутгийн байгаль хамгаалахад олон нийтийн оролцоог дээшлүүлэх

Байгальд ээлтэй сургуулийн үйл ажиллагааг сурталчлах ажлыг тус суманд хэрэгжүүлж байгаа нь “Бэлчээр-ногоон алт” төслийн багтай хамтран хөдөө багуудад нийт 6 удаа сургалт зохион байгуулж, үүнд давхардсан тоогоор 134 хүнийг хамрууллаа. Байгаль хамгаалах сарын ажлыг жилд 2 удаа зохион байгуулж явуулсны дээр 5-р сард “Сургууль, эцэг эхийн хамтын ажиллагаа” 1- өдрийг зохион байгуулж энэ үеэр эцэг эхчүүд сургуулийн орчинд багш сурагчидтай хамтран 100 ш мод тариалаа.

Долдугаар алхам: Байгальд ээлтэй сургууль болох зорилтыг хэрэгжүүлэх талаар бүх талын үйл ажиллагааг идэвхижүүлэх

Эко код, лого, уриа: Уриа: “Байгальд – хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлье”

Логооны тайлбар “Байгаль эх дэлхийгээ өөрийн амь шигээ хайрлацгаая гэсэн утга санааг илэрхийлсэн хөрс шороон дээр 2 гар дээрээ байгаль орчноо өргөн дээдэлэе” гэсэн утга санааг илэрхийлсэн болно.

- 3. Тэргүүн туршлага:** Байгальд ээлтэй сургуулийн үйл ажиллагааг сурталчлах ажлыг тус суманд хэрэгжүүлж байгаа нь “Бэлчээр-Ногоон алт” төслийн багтай хамтран хөдөө багуудад нийт 6 удаа сургалт зохион байгуулж, үүнд давхардсан тоогоор 134 хүнийг хамрууллаа.

“Бэлчээрийн –Ногоон алт” төслийн багтай хамтран сумын төвийн орчимд 800 гаруй бургас хайлаас, чацарганы бут суулгаж цаашид энэ газрыг хичээл туршилтын талбай болгон ашиглахаар төлөвлөж байгаагийн дээр энэ ажилд эцэг эхчүүдээс 10 гаруй хүн, багш 17, сурагчид 170 тус тус оролцлоо.



Мөн байгаль орчны хичээлийн хөтөлбөрт тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг уялдуулж оруулж өгснөөр багш, сурагчдын байгальд хандах хандлагад эрс өөрчлөлт гарч байгальд ээлтэй эдийн засгийн хөгжил нь нийгмийн хөгжлийн тулгуур гэдгийг ухамсарлах.



Суурь боловсролын түвшинд биологи, газарзүй, математик, хими зэрэг хичээлүүдийн хүрээнд тогтвортой хөгжлийн үзэл санааг зарим сэдвийн агуулгад оруулан зааж туршиж байна. Орон нутгийн малчид, иргэдтэй хамтран байгаль орчноо хамгаалахад тэдний оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр булаг, шандыг хамгаалах, хадлангийн талбай бий болгох, зарим ундрага нь багасаж байгаа гол горхийн эхийг хамгаалж мод тарих, ажлыг хийснээр зарим булаг, шанд, гол горхи сэргэж урсац нь нэмэгдэж байна.